

2022 он 02 сар 16 өдөр

Дугаар 22/03

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Ногдол ашиг хуваарилах эсэх тухай*

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.7, 70 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, ТУЗ-ийн 2022 оны 2 сарын 16-ны өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас 99.87% (ерэн ес зууны наян долоо)-иар буюу 1,333,000,000 (нэг тэрбум гурван зуун гучин гурван сая) төгрөгийг мөнгөн болон хуульд заасан бусад хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 46.58 төгрөгтэй тэнцэх ногдол ашгийг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг хүртэх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахтай холбоотой төлбөр тооцоог “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-иар зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2022 оны 6 дугаар сарын 22-ны дотор олгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ хэлцэл байгуулах, гэрээнд гарын үсэг зурахыг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор (М.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



П.БАТБАЯР